

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: Төрийн банк ХК УБД: 9016001018 Үнэт цаасны код: MN00SBM05643 Утасны дугаар: 976-11-310103
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүү
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	"Эрнст энд Янг монголия аудит" ХХК Бүртгүүлсэн огноо: 2013-05-08
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	755,096,250
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайланг бэлтгэсэн: П.Мөнхтуяа /Хөрөнгө зохицуулалтын газрын мэргэжилтэн/ Хянасан: Д.Жадамбаа /Хөрөнгө зохицуулалтын газрын захирал/
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ Санхүүгийн байдлын үзүүлэлт Орлогын тайлан Өмчийн өөрчлөлтийн тайлан Мөнгөн гүйлгээний тайлан
	Жилийн санхүүгийн тайланг хавсаргав. Хавсралт №1
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	Жилийн санхүүгийн тайланг "Эрнст энд Янг монголия аудит" ХХК-ын баталгаажуулсан аудитын дүгнэлтийг хавсаргав. Хавсралт №2
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/
	"Эрнст энд Янг монголия аудит" ХХК хөндлөнгийн хараат бус аудит хийж, дүгнэлт гаргасан тухай аудитын тодорхойлох захидал нь Хавсралт №2-ын аудитын дүгнэлтэд тусгагдсан.
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/
	Аудитлагдсан санхүүгийн тайлангаар балансын гол үзүүлэлтүүд болох нийт активын хэмжээ 2023 онд өмнөх онтой харьцуулахад 28.9 хувиар өсч 5,368.3 тэрбум төгрөгт, голлох орлого олдог активууд/зээл, үнэт цаас/өмнөх онтой харьцуулахад 18.1 хувиар өсөж 3,781.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт пассивын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 30.7 хувиар нэмэгдэж 4,792.9 тэрбум төгрөгт, өөрийн хөрөнгийн хэмжээ 15.9 хувиар нэмэгдэж 575.3 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Орлогын тайлангийн гол үзүүлэлтүүд болох хүүгийн орлого 2023 онд 500.6

“Төрийн банк” ХК

		<p>тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 23.6 хувиар, хүүгийн зардал 256.5 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 40.3 хувиар тус тус өссөн байна. Хүүгийн зардлын өсөлтөнд “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай” хуулийн хэрэгжилтийн хүрээнд банкууд харилцах, иргэдийн хугацаагүй хадгаламжид хүү тооцож эхэлсэн болон 2022 онд Монголбанкны бодлогын хүү үе шаттайгаар 7 нэгж хувиар өсч 13 хувьд хүрсэнтэй холбоотой банкуудын хадгаламжийн хүү өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Банк 2023 онд 94.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Банкны өөрийн хөрөнгийн өгөөж 2023 онд 18.94 хувь, активын өгөөж 2.31 хувь байна.</p>																		
2.2.	<p><i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i></p>	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="756 703 1187 775">Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт</th> <th data-bbox="1187 703 1347 775">Байвал зохих</th> <th data-bbox="1347 703 1485 775">Биелэлт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="756 775 1187 869">Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа</td> <td data-bbox="1187 775 1347 869">> 9%</td> <td data-bbox="1347 775 1485 869">21.60%</td> </tr> <tr> <td data-bbox="756 869 1187 936">Өөрийн хөрөнгө болон эрсдлээр жигнэсэн активын харьцаа</td> <td data-bbox="1187 869 1347 936">> 12%</td> <td data-bbox="1347 869 1485 936">21.60%</td> </tr> <tr> <td data-bbox="756 936 1187 1003">Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт</td> <td data-bbox="1187 936 1347 1003">> 25%</td> <td data-bbox="1347 936 1485 1003">45.68%</td> </tr> <tr> <td data-bbox="756 1003 1187 1093">Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)</td> <td data-bbox="1187 1003 1347 1093">< (+ - 15%)</td> <td data-bbox="1347 1003 1485 1093">-7.04%</td> </tr> <tr> <td data-bbox="756 1093 1187 1189">Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)</td> <td data-bbox="1187 1093 1347 1189">< (+ - 30%)</td> <td data-bbox="1347 1093 1485 1189">-7.23%</td> </tr> </tbody> </table>	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа	> 9%	21.60%	Өөрийн хөрөнгө болон эрсдлээр жигнэсэн активын харьцаа	> 12%	21.60%	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	> 25%	45.68%	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	< (+ - 15%)	-7.04%	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	< (+ - 30%)	-7.23%
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт																		
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа	> 9%	21.60%																		
Өөрийн хөрөнгө болон эрсдлээр жигнэсэн активын харьцаа	> 12%	21.60%																		
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	> 25%	45.68%																		
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	< (+ - 15%)	-7.04%																		
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	< (+ - 30%)	-7.23%																		
2.3.	<p><i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i></p>	<p>Гадаад орчны төлөв байдлаар дэлхийн эдийн засгийн 2023-2025 оны өсөлтийн төсөөлөл өмнөх төсөөллөөс нэмэгдэв. Үүнд: БНХАУ-ын цар тахалтай тэмцэж буй бодлогын арга хэмжээ суларснаар тус улсын үйлчилгээний салбарын өсөлт 2023 оны 1 дүгээр улиралд хүлээлтээс хурдтай сэргэсэн. Нийлүүлэлтийн сүлжээний доголдол харьцангуй сайжирч, тээврийн зардал буурч байгаа нь голлон нөлөөлсөн байна. Гэхдээ ОХУ-Украины нөхцөл байдалтай холбоотой тодорхой бус байдал болон АНУ, Европын холбоо зэрэг томоохон эдийн засагтай улсуудын банк, санхүүгийн зах зээлд үүсээд буй хүндрэл цаашид даамжрах эрсдэл нь өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.</p> <p>Банкны системийн нийт актив 57.1 их наяд төгрөг хүрсэн ба Төрийн банкны актив 5.3 их наяд төгрөгт хүрч 9.3 хувийг эзэлж байна. Манай банк нийт 2.3 сая харилцагчид 115 төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэн ажиллаж байна. 2023 онд бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн дундаж давхаргыг дэмжих санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, банкны бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх зорилгоор дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээл шинээр нэвтрүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлийг сайжрууллаа.</p> <ul style="list-style-type: none"> • Гялсбанк 3.0 хувилбарыг шинэчлэн нэвтрүүллээ • Цалингийн цахим зээл, Тэтгэврийн цахим зээл, Гялс зээл, Пос-ын орлого барьцаалсан цахим зээл • Qray 2.0 үйлчилгээ шинэчлэгдлээ • “Хувийн тэтгэврийн сан” хадгаламжийг шинээр гаргалаа. 																		

“Төрийн банк” ХК

		<ul style="list-style-type: none"> • “Авто зогсоол худалдан авах зээл”-ийг төрөлжүүлэн нэвтрүүлээ • “Шуурхай бизнесийн зээлийн эрх” бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээ • Эрүүл иргэн картыг шинээр нэвтрүүлээ • Виртуал картыг онлайнгаар авах боломжтой боллоо • Цалингийн виза картыг шинэчлэн гаргалаа • “Эрүүл иргэн” хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүнийг БНСУ эмнэлэгт үйлчилгээ авах боломжтойгоор төрөлжүүлээ • Гадаадад ажиллаж амьдарч буй монгол иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг хөнгөлөлттэй нөхцөлөөр авах боломжийг бүрдүүлээ • Сургалтын төлбөрийн зээлийн нөхцөлийг сайжруулан “Боловсролыг дэмжих зээл” болгож шинэчилээ • Малчны зээлийн хэмжээг нэмж хугацааг уртасгалаа • “Хувийн дугаар” үйлчилгээний нөхцөлийг сайжрууллаа • Төрийн банк, ххб, голомт банк, капитал банкны атм-с картын шимтгэл харилцан 100₮ болж буурууллаа. 											
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх тайланг хавсаргав. Хавсралт №3											
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	<p>Cargill Financial Services Internation Inc- ээс дараах эх үүсвэрийг татсан.</p> <table border="1"> <thead> <tr> <th>Татсан үнийн дүн</th> <th>Хугацаа</th> <th>Эх үүсвэрийн зориулалт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>25 сая ам.доллар</td> <td>2 жил</td> <td rowspan="2">Банкны гадаад худалдааны зээлийг дэмжих эх үүсвэр</td> </tr> <tr> <td>13 сая ам.доллар</td> <td>3 жил</td> </tr> <tr> <td>17 сая ам.доллар</td> <td>2 жил</td> <td>Банкны хөдөө аж ахуйн зээлийг дэмжих эх үүсвэр</td> </tr> </tbody> </table>	Татсан үнийн дүн	Хугацаа	Эх үүсвэрийн зориулалт	25 сая ам.доллар	2 жил	Банкны гадаад худалдааны зээлийг дэмжих эх үүсвэр	13 сая ам.доллар	3 жил	17 сая ам.доллар	2 жил	Банкны хөдөө аж ахуйн зээлийг дэмжих эх үүсвэр
Татсан үнийн дүн	Хугацаа	Эх үүсвэрийн зориулалт											
25 сая ам.доллар	2 жил	Банкны гадаад худалдааны зээлийг дэмжих эх үүсвэр											
13 сая ам.доллар	3 жил												
17 сая ам.доллар	2 жил	Банкны хөдөө аж ахуйн зээлийг дэмжих эх үүсвэр											
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээллийг хавсаргав. Хавсралт №4											
4.	Цалин урамшууллын мэдээлэл												
	Тайлант хугацааны туршид банкны захирлууд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгосон нийт цалин урамшууллын дүн 1,961,814,000 (Нэг тэрбум есөн зуун жаран нэгэн сая найман зуун арван дөрвөн мянга/ төгрөг байна.												
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	Компанийн засаглалтай холбоотой мэдээллийг хавсаргав. Хавсралт №5											
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл												
	Тайлант хугацаанд Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон АПУХ-ноос тогтоосон хязгаарлалтуудыг бүрэн хангаж ажиллалаа. Төрийн банк нь зах зээлийн эрсдэлийг үнэлэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн гадаад валютын ханшийн эрсдэлээс сэргийлэн Монголбанктэй своп хэлцэл хийн ажилладаг. Макро эдийн засгийн нөхцөл байдлын судалгаа, түүнийг үндэслэн банканд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон, стресс тестийн шинжилгээ хийн удирдлагуудыг мэдээллээр ханган, шийдвэр гаргалтанд дэмжлэг үзүүлдэг. Төрийн банк нь зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн хүндрэлт үед хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд шаардлагатай нөхцөл байдал үүсвэл тус төлөвлөгөөний дагуу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.												

“Төрийн банк” ХК

7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/																		
	Нийт гаргасан хувьцаа:755,096,250 ширхэг Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо: 8,711 Хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшлийн хувь: Сангийн яам- 49.26% Хадгаламжийн даатгалын корпораци -45.03% , Олон нийт-5.71%																		
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл																		
	Төрийн банк нь Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд, системийн нөлөө бүхий банкууд олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох үүргийн хэрэгжилтийг ханган 2022 оны 10 дугаар сард Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжиж, нийт 25.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг банкны үндсэн үйл ажиллагааг дэмжих, үүн дотроо Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчимд нийцсэн Тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүнд 12.7 тэрбум, Дундаж давхаргад чиглэсэн бүтээгдэхүүнд 12.7 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна. Төр засгаас явуулж буй бодлого шийдвэрүүдэд нийцүүлэн Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, орон нутгийн иргэд, жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх чиглэлийг баримталж нийт зарцуулалтын дүнгийн 61 хувь буюу 15.5 тэрбум төгрөгийг орон нутагт олгож татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг төлөвлөгөөний дагуу бүрэн зарцууллаа.																		
9.	Ногдол ашгийн мэдээлэл																		
	2022 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай: “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолын дагуу банкны 2022 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж, ногдол ашгийг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан болно.																		
	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="322 1176 387 1238">№</th> <th data-bbox="387 1176 1114 1238">2022 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай тайлан</th> <th data-bbox="1114 1176 1487 1238">Утга</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="322 1238 387 1272">1</td> <td data-bbox="387 1238 1114 1272">Ногдол ашгийг олгож эхэлсэн огноо</td> <td data-bbox="1114 1238 1487 1272">2023.04.28</td> </tr> <tr> <td data-bbox="322 1272 387 1305">2</td> <td data-bbox="387 1272 1114 1305">Энгийн хувьцаа</td> <td data-bbox="1114 1272 1487 1305">755,096,250 /ширхэг/</td> </tr> <tr> <td data-bbox="322 1305 387 1339">3</td> <td data-bbox="387 1305 1114 1339">Хувьцаа эзэмшигчдийн тоо</td> <td data-bbox="1114 1305 1487 1339">7,867</td> </tr> <tr> <td data-bbox="322 1339 387 1402">4</td> <td data-bbox="387 1339 1114 1402">Нэгж хувьцаанд оногдуулан хуваарилсан ногдол ашгийн хэмжээ</td> <td data-bbox="1114 1339 1487 1402">63.68 /төгрөг/</td> </tr> <tr> <td data-bbox="322 1402 387 1435">5</td> <td data-bbox="387 1402 1114 1435">Ногдол ашиг олгосон дүн</td> <td data-bbox="1114 1402 1487 1435">48,084,529,200 /төгрөг/</td> </tr> </tbody> </table>	№	2022 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай тайлан	Утга	1	Ногдол ашгийг олгож эхэлсэн огноо	2023.04.28	2	Энгийн хувьцаа	755,096,250 /ширхэг/	3	Хувьцаа эзэмшигчдийн тоо	7,867	4	Нэгж хувьцаанд оногдуулан хуваарилсан ногдол ашгийн хэмжээ	63.68 /төгрөг/	5	Ногдол ашиг олгосон дүн	48,084,529,200 /төгрөг/
№	2022 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилсан тухай тайлан	Утга																	
1	Ногдол ашгийг олгож эхэлсэн огноо	2023.04.28																	
2	Энгийн хувьцаа	755,096,250 /ширхэг/																	
3	Хувьцаа эзэмшигчдийн тоо	7,867																	
4	Нэгж хувьцаанд оногдуулан хуваарилсан ногдол ашгийн хэмжээ	63.68 /төгрөг/																	
5	Ногдол ашиг олгосон дүн	48,084,529,200 /төгрөг/																	
	2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай: “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 10 дугаар тогтоолын дагуу банкны 2023 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 66.20 /жаран зургаан төгрөг хорин мөнгө/ төгрөг буюу нийт 49.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”ХХК-аар дамжуулан эрх бүхий этгээдийн зөвшөөрөл шийдвэр ирснээс хойш 60 хоногийн дотор олгохоор шийдвэрлэсэн.																		
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн харууцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл																		
	<p>1.“МИНИЙ МОНГОЛ-2023” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА - Төрийн банк ХК нь өөрийн харилцагч, жижиг дунд үйлдвэр эрхлэгч нарыг олон нийтэд сурталчлан таниулах, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлж, банкны цогц үйлчилгээг олон нийтэд хүргэх зорилгоор “Миний Монгол-2023” үзэсгэлэн худалдааг амжилттай зохион байгууллаа.</p> <p>2.“ХҮНДЭТГЭЛИЙН АЯН-2023” - Сар шинийн баярыг угтан Төрийн банк ХК нь хамгийн өндөр настай харилцагч нартаа хүндэтгэл үзүүлээ.</p> <p>3.“ХАРИЛЦАГЧИЙН ӨДӨРЛӨГ-2023” АЯН - Жил бүр зохион байгуулдаг “Харилцагчийн өдөрлөг” арга хэмжээг 2023 онд 10 аймаг, 2 дүүрэгт зохион байгуулж банкны бүтээгдэхүүн үйлчилгээг 24,300 харилцагчид борлуулсан.</p> <p>4.“ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ-2023” - Монголбанк, Монголын банкны холбооноос зохион байгуулсан “Дэлхийн мөнгөний долоо хоног 2023” аяныг “Санхүүгээ зөв</p>																		

“Төрийн банк” ХК

төлөвлөж, ирээдүйгээ бүтээцгээе” уриан дор нийт салбар, нэгжээрээ дамжуулан 56,808 оюутан, сурагчдад “Санхүүгийн боловсрол” олгох сургалтыг амжилттай зохион байгуулсан.

5.ХҮРЭЭЛЭН ТӨСӨЛ - Байгаль эхээ хамгаалах, хойч үеэ байгальд хайртай иргэн болгох зорилгоор Хүрээлэн төсөлтэй хамтран 2020 онд “Эко карт”-ыг зах зээлд нэвтрүүлсэн. 2023 онд 23,051 ширхэг Эко карт борлуулж, 23.0 сая төгрөгийг ховор амьтдыг хамгаалах үйлсэд зориулав.

6.“БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР”-Т ТӨРИЙН БАНК НЭГДЛЭЭ - “Тэрбум мод” тарих үндэсний хөтөлбөрийг дэмжиж, манлайлан ажиллах уриалгыг дэвшүүлэн 5 сая мод тарих зорилт тавин 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт тус аяныг уламжлал болгон ажиллаж байна. Тайлант онд 2023 оны 05 дугаар сар болон 10 дугаар сард “МОДЫГ МОД(А) БОЛГОЁ-АЖИЛТАН БҮР НЭГ МОД” аяныг Төрийн банк ХК-ийн нийт ажилтнуудын дунд зохион байгуулж орон даяар 34 нэр төрлийн 6,586 ширхэг мод тарьж мөн сургууль цэцэрлэгийн орчинд 702 мод, 300м2 талбайд зүлэгжүүлэлт, 50м2 талбайд цэцгийн мандал хийлээ.

7.“ГЯЛС ЦЭВЭРЛЭГЭЭ” АЯН - Төрийн банк ХК-ийн нийт ажилтнуудын хүрээнд “Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ-2023” аяныг 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдөр нэгдсэн байдлаар өрнүүлсэн. Аяныг Монгол орон даяар 21 аймгийн 315 суманд зохион байгуулж 7,440 га талбайг цэвэрлэж, 800 тонн буюу нийт 420 орчим автомашин хог хаягдлыг цэвэрлэв.

8.ЗӨВЛӨМЖ, МЭДЭЭЛЭЛ – Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран Цаг агаарын болзошгүй аюул, гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх 40 удаагийн мэдэгдлийг “Гялсбанк аппликейшн”-аар дамжуулан давхардсан тоогоор 972,556 харилцагчид хүргүүлээ.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ө.ГАНТӨР

Албан тушаал: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.ЖАДАМБАА

Албан тушаал: ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Гарын үсэг:

